

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Санжидын Дэндэв	Дугаар	L103
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Жаргалтхаан
Төрсөн газар	Жаргалтхаан сум	Төрсөн он	1914
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Уугийн хийд, Баатарын дацан	Сүм хийдийн дугаар	ХЭЖХ 014, ХЭЖХ 010
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 16	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Уугийн хийд, Баатарын дацан

-Жаргалтхаан таны төрсөн нутаг уу?

Тийм. Жаргалтхаанд Баатарын дацан гэж том хийд бий. Жаргалтхааны хийд гэвэл Тахилтат Хутагтын хүрээ гэж бий. Өөр юу ч байхгүй дээ.

Тахилтын хийд гэж бий юу?

- Тийм. Тахилтын хийд

Уртын хийд гэж ганц дугантай юм байсан юм. Мэргэн хамбын хийд гэж.

Уугийн отог гэдэг чинь Уу дотроо Дэчинлхүндэвлэн гэдэг хийд байсан юм.

- Тийм тийм.Бид нар явах замдаа бүгдээр нь орсон. Та одоо энэ хийдүүдийнхээ тухай ямаршуу хийдүүд байсан юм. Хэр олон дугантай? Хэдэн ламтай хийд байсан? гэдгийг лавлах гэсэн юм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Уугийн хийд зун бол 50,60-аад болчихдог, өвөл 20,30-аад ламтай болчихдог байсан. Тэр Уугийн хийд гэдэг чинь Уугийн хурал шүү дээ. Уугийн хийд гэдэг чинь Уулын отгийнхны хийд буюу их мандал хурж байгуулагдсан юм гэнэ лээ. Өөхөн мандал гэж их өөх тостой махан цавтай мандал хурсан юм гэнэ лээ. Тэгээд өөхөн мандал гэж нэрлэсэн юм. Уугийн хийд 3 дугантай. Нэгийг нь сүүлд манай багш хурал гаргасан юм. Багшийнхаа буянд зориулж. Тэр багш нь Гандангийн хүн. Тэгээд Ганжуурын лүн тавиулаад. Цэнхэрмандалын Бямба цорж гэдэг хүнээр Ганжуурын лүн тавиулж байсан.

-Та Гичгиний хурлын талаар ярьж өгөхгүй юу?

Би тэр холын хурлыг мэдэхгүй. Очиж хурж ч байгаагүй.

- Та багадаа аль хийдэд шавилан сууж байв даа?

Ууд. Суух ч юу байхав. Ирж очин байсан. Хааяа хурлаараа хэд хоног байчихаад л. Цагийн хуралд зуны Санжид хурахад 5,6 хоног, Ганжуур магтаал хурахад 8,9 хоног, намрын Хангалд 7,8 хоног хурна даа. Манлаар эхлээд тэгээд Дарь эх тэгээд Аюуш, тэгээд Лхам, Хангал 3 өдөр.

-Уугийн хурал хэдэн онд байгуулагдсан хийд юм бэ?

Их дээр үед юм гэсэн. Би мэдэхгүй. Уулын отгийн хийд гэдэг чинь дээшээ мэдээтэй бүрээ шаттай хурал байсан юм. Мэдээтэй хурал гэдэг чинь бүрээ шаттай байсан юм гэнэ лээ. Хэнгэрэг гарч цохидог, бүрээ үлээдэг шат байсан. Манай Уугийн хурал гэдэг чинь мэдээтэй хурал байсан юм. Баатарын дацан гэж тэр урд байсан юм. Би орж үзээгүй. 4,5 дугантай байсан. Нэг явж байсан. Цогчэн дуган гэж том дуган харагдаж байсан. Хөдөөдөө л том л доо. Тэрнээс тийм том биш. Гичгиний хурал, Тахилтын хурал, Уртын хурал. Уртын хурал гэдэг чинь Мэргэн хамбын хурал гээд байсан.

- Уртын хурал хэр олон дугантай? Хэдэн ламтай байсан бэ?

Ганцхан дугантай.

- Бөөрөнхий гэр дуган байсан уу?

Мэдэхгүй ээ, бөөрөнхий байсан байх аа. Манайх чинь Уу дотроо зуны дуган, өвлийн дуган гээд хоёр дугуй дугантай байсан. Сүүлд нь манай багш өөрийнхөө багш, Гунгаачойлонгийн шунлайв байсан хэн билээ тэр багшдаа зориулж хурал гаргасан.

-Уугийн хийд маань ямар сахиустай байсан гэлээ?

Чойжоо сахиустай байсан.

-Гол ядам нь ямар ядамтай байсан юм бэ?

Чойжоогоороо л ядамладаг байсан байх. Би мартчихсан байна. Уугийн хурал гэдэг чинь Уулын отгийн хийд, Бугын өвөр бумбан талбай дээр хийд байсан юм.

-Тиймээ бид очиж үзсэн.

Хэзээ, сая уу?

- 6 сард.

Тэгээд газарчилж явах хүн байна уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

- Байна аа.

Хэн гэдэг хүн явав?

-Санжаа лам

Манайхны Санжаа юу?

-Тийм тийм. Цэндсүрэн гуайн хүү Санжаа лам.

Цэнхэрийн хурал гэж ганцхан Санжаа лам байгаа биз дээ. Нэлээд хэдэн ламтай аюулгүй хурдаг байсан.Тэгээд болилоо

-Уугийн хурал хурлуудын хувьд ямар ямар хурал хурдаг байсан бэ?

- Зуны сард зуны санжид гэж 5 хоног хурна. Ганжуур магтаал гэж сүүлд нь 7,8 хоног хурна, намар Хангал гэж бас 7,8 хоног хурна. Намрын Хангал. Манайхан чинь хурал эхлэхдээ их Манлаар эхэлдэг тэгээд Дарь эхийн манла шиваа байдаг байсан. Их манал хурдаг байсан. Аюуш хурна. Гомбо яам Чойжоо яам, Лхам яамтай 3 өдөр 3 хангалаар яамладаг. Жижиг дагавар нь тэгээд яахав Гомбо, Намсрай, Жамсран гэх юм уу, Чойжоо, Шалш ч гэх юм уу тэгээд тэгээд хуваагаад хуваагаад яамлачихдаг байсан юм. Намар 3 хоног Хангал хурна. Гомбо яам, Чойжоо яам, Лхам яамтай гэсэн 3 яамтай. Тэгээд зуны хурал, намрын хурал гэж байгаа. Зуны санжид гэж хамгийн түрүүнд 5 өдөр хурдаг байсан. Тэр нь Манлаар эхэлдэг байсан. Тэгээд зуны Санжид чинь Манлаар эхлээд Дарь эхийн Манла шиваа энэ тэр хурна. Тэгээд сахиусаа таван өдөр хураад тардаг байсан. Магтаал бас нэг 10 арай хонохгүй ээ. Жижиг сажиг хурал магтаалтай 4 хоног хурдаг байсан. Тэгээд намрын Хангал гэж хурдаг байсан.

-Хэр олон ламтай байсан бэ?

Нэг их олноороо суудаггүй. Одоо манай хөдөөнийх гэвэл Баатарын дацанд их олноороо суудаг байсан.

-Тэр хавьдаа том, Майдар эргэж, хайлан хурдаг байсан гэсэн?

Тиймээ том хийд байсан.

-Уугийн хийдэд Майдар эргэж , хайлан хурдаг байсан уу?

Үгүй. Байгаагүй. Майдар эргэхийг үзээ ч үгүй. Цамтай газар Хутагтын хүрээ л байсан.

- Баатарын дацан цам гардаг байсан уу?

Үгүй ээ үгүй. Хутагтын хүрээ одоо юу ч байхгүй. Хүрээ байсан гэхээр юм юу ч байхгүй байгаа биз дээ. Одоо суурь нь үлдсэн. Баруун хойно Эрээтэд нэг суурь байна уу үгүй юу.

- Байна лээ. Жодын хурал гэж байсан байна лээ. Цэнхэрмандалын хийдүүдээс аль алийг нь та мэдэх вэ?

- Мэдэхгүй ээ. Цэнхэрмандалын хийд гэдэг чинь Бор Өндөрийн хийд гэж байсан юм. Хойно нь Согтуугийн хурал гээд голд байсан юм. Согтуугийн хурал гээд отгийн айлууд буучихсан, гүү барьчихсан, тогоо нэрчихсэн, хүмүүс согтчихсон байж байдаг байсан. Тэгээд л Согтуугийн хурал гэж нэрлэсэн байх. Согтуугийн хурал гэж Барэйвүнгийн цамд явж байхад би нэг дайрч байсан юм байна.

- Далбангийн хурал гэж ямар хурал байсан юм вэ?

- Далбансогоот гэж Цэнхэрмандалд байсан. Тэрнийг би мэдэхгүй.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

- Даянтын хурал гэж байсан байна?

Мэдэхгүй ээ.

-Тэр Тойн ламын хурал нь хэдийн үеэр хэдэн онд байгуулагдсан юм бол доо?

Их л дээхнэ үед байгуулагдсан юм гэнэ лээ.

-Төвд нэр нь юу гэдэг байсан юм бол?

Мэдэхгүй мартсан байна.

-Хөхтийн хурлыг та мэдэж байна уу? Цэнхэрмандал Хэрлэнбаянгаас хойшоо?

- Үгүй мэдэхгүй. Дуулдаж л байсан бага байхад.

-Танай Жаргалтхааны хийдүүдийн төвд нэрүүдийг юу гэдэг байсан юм бэ? Баатарын хийдийг Пунцагдэгчилин хийд, танайх Дэчинлхүндэвлэн юм уу?

-Тийм. Дэчинлхүндэвлэн. Хоёрхон дугантай нь Уулын отгийн хийд.

-Гичгиний хийд, Цагаан суварга, Мэргэн хамба эд нарыг мэдэхгүй юу?

- Мэдэхгүй.

-Тахилтын хийд?

- Очиж хурж байгаагүй болохоор мэдэхгүй юм.

- Өөр Уугийн хийд наад хийдүүд таны өөрийн санаж байгаа хийдүүдээс онцлох юм юу байна? Ямар ямар байшин байна.Нураах балрах үеийн лам нар хийгээд ард иргэдийн байдал ?

Лам нар ч яахав. Манай Уугийн хийд ч яахав зуны, өвлийн 2 дугантай, нэг багшийн гаргасан Жүд гэдэг хуралтай нийтдээ 3 дугантай хурал байсан. Манай багш багш нь байсан Гандагийн шунлайв ч байсан юм уу тэр хүндээ зориулж Жүдийн хурал гэж гаргасан. Тогтмол гүнрэг хурна. Багш гүнрэгэнд айхтар. Багш гүнрэг хурахдаа 2 өдөр 3 өдөр шахуу хурна.Гүнрэгийг овоо сураад одоо байхгүй болсон. Багш их шооч. Өөрөө хурал гаргасан хүн. Шовгор Лувсанцэрэн гэж Гандангийн шунлайв байсан хүн юм гэнэ лээ. Тэгээд тэр багшийнхаа төлөө хурдаг. Гүнрэг хурал хоёр гурван өдөр. Харин ёстой нэг нэр нь барагдахгүй дээ. Өөрөө баахан нэртэй байна. Амьтнаас баахан нэр ирнэ. Тэгээд болохгүй бол Дэлгэрхаан хошууны хоёр хүн хэлдэг байсан юм. Тэр хоёроос л хэн хэн ямар нэртэй хүн ирсэн бэ гээд л тэр хоёрыг байцаачихна. Тэгээд хавийн амьтанаас хүний нэр асуугаад л тэгээд өнөө лам нар чинь тус бүрдээ нэр өгнө. Барагдахгүй, тэгээд заримыгаа шоолоод л. Манай багш тэгж хурал гаргаж байсан хүн. Жүдийн жас гэж гарсан юм. 4 цагийн жүд хурна, тэгээд 2,3 өдөр яндаг вантай гүнрэг хурна.

-Уугийн хурлыг анх хэн санаачилсан юм болоо?

- Мэдэхгүй. Одоо отог нь санаачилсан байх. Манлаар л гарсан юм гэнэ лээ. Их Манла хурж гарсан юм гэнэ лээ.

Тэгээд махан цавтай өөхөн манла нэртэй. Уугийн отгийн хурал гэдэг чинь зуны өвлийн хоёр жаахан дугантай. Дэчинлхүндэвлэн гэдэг нэртэй байсан юм.

-Юуны суурин гэнээ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ингэний суурин Суурин гэж байсан тэрний шүтээн. Ингэний шүтээнийг Архай Жигмэд гэдэг хүн хойш нь аваачсан юм.

- Хайлантад уу?

Хайлантын аманд. Баяны баруун энгэрт харагдаж байсан. Ингэн гэдэг газар шүтээн байсан юм.

- Тэр одоо аль нутагт орох вэ? Ингэний шүтээн хүүчин.

Дэлгэрхаан.

- Дэлгэрхааны нутаг уу?

Тийм. Дэлгэрхааны тэрүүхэн урд. Ингэний шүтээнийг Архай Жигмид гэдэг хүн Хайлантад аваачиж хуруулсан гэдэг. Хэд хоног хуруулсан.

-Тэр шүтээн ямар учиртай шүтээн байсан вэ?

-Мэдэхгүй би очиж үзээгүй. Жижигхэн л юм байсан.

- Мааньтын хийд нь?

Мэдэхгүй. Мааньт гэдэг нь хийд байхаа. Би тэрийг мэдэхгүй. Манай уулын хийд гэдэг чинь Бугын өвөр Бумбан толгойн өвөрт байсан юм.

- Тэр үед байсан Уртын мэргэн хамбын дараа дараагийн дүрийг тодруулж байсан уу?

- Мэдэхгүй. Тодорч байсан гэсэн байхаа.

-Хэдэн удаа тодруулж байсан юм бол?

- Мэдэхгүй. Мэргэн хамбын хийд гэж л байсан гэсэн. Манайханд тэрнээс өөр хувилгаадын хийд байгаагүй байх. Баянзүрхийн өврийн суурин дээр Тойн лам гэж хувилгаан хүн байсан.

- Тэр хүний хэдэн дүрийг нь тодруулсан вэ?

Сүүлд л нэг өвгөн байж байгаад ахиж дүр тодроогүй. Урьд нь хэдэн дүр тодорсныг мэдэхгүй. Бор Өндөрийн хурал гэж байсан. Тэр дээр чинь Согтуугийн хурал гэж Түрүүгийн булангийн тийшээ байсан юм. Согтуу 8 айл буугаад гүү барьсан тогоо нэрчихсэн дугандаа архи барьдаг байсан гэдэг.

-Тэр яагаад тэгдэг байсан юм бол?

- Мэдэхгүй.

-Тэр хурал шарынх байсан биздээ?

- Тийм шарынх байсан. Тэгээд 8 айл намрын хурлаар буучихдаг гүү барьчихсан тогоо барьчихсан байдаг байсан юм гэнэ лээ. 8 айл ч байдаг л байсан л даа.